




МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



**“Аж ахуйн нэгжийн үйл
ажиллагаанд Корона вирус
(Covid-19)-ээс урьдчилан
сэргийлэх, хөл хорио тогтоох
арга хэмжээний үзүүлсэн
нөлөөлөл” 2 дахь шат**

Улаанбаатар хот
2020 он

Монгол Улсын Засгийн газраас дэлхий нийтээр тархсан шинэ төрлийн корона вируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлэх шийдвэр гаргаж, түүнээс хойш бэлэн байдлын зэргийг 8 удаа сунгаад байна.

Иймд ҮСХ-ноос “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вирус (Covid-19)-ээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл” хоёр дахь шатны онлайн тандалт судалгааг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн гаргалаа.

Манай улсад 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 195.7 мянган ААНБ бүртгэлтэй байгаа бөгөөд 49.2 хувь (96.0 мянга) нь үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 39.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарынх байна.

Хүснэгт 1. Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, салбарын ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2020 оны эхний хагас жилийн байдлаар

Үйл ажиллагааны чиглэл	Эзлэх хувь	
	Тухайн салбарын нийт ААНБ-ын дүнд	Үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын дүнд
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	47.9	39.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	48.6	10.0
Барилга	51.2	8.0
Боловсруулах үйлдвэрлэл	50.7	6.8
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	48.3	5.5
Боловсрол	65.2	4.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	42.5	3.9
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	35.0	3.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	75.9	2.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	53.0	2.6
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	48.2	2.4
Мэдээлэл, холбоо	40.1	2.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	41.2	1.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	100.0	1.7
Уул уурхай, олборлолт	49.5	1.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	58.9	1.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	53.6	1.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	74.5	0.3
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	65.2	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	100.0	0.0
Нийт	-	100.0

ҮСХ-ноос “ААНБ-ын үйл ажиллагаанд Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл”-ийн эхний шатны тандалт судалгааг 21 аймаг, 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 2402 ААНБ-аас 2020 оны 5 дугаар сарын 6-20-ны өдрүүдэд онлайн хэлбэрээр цуглуулан авч үр дүнг 6 дугаар сард тархаасан.

Хоёр дахь шатны тандалт судалгааны мэдээллийг 2020 оны 7 дугаар сарын 27-ноос 8-р сарын 10-ны өдрүүдэд цуглуулав.

“Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вирус (Covid-19)-ээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл” хоёр дахь шатны тандалт судалгаанд эхний шатны судалгаанд оролцсон 2402 аж ахуйн нэгж дахин хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан 2402 аж ахуйн нэгжийн 1255 (52.2%) нь үйл ажиллагаа нь хэвийн, 1147 (47.8%) нь Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээнээс шалтгаалан хэвийн явагдахгүй байна гэсэн хариулт өгчээ.

Үйл ажиллагаа нь хэвийн болон хэвийн явагдахгүй байгаа гэсэн хариулт өгсөн ААН-үүдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харуулбал (Хүснэгт 2):

Хүснэгт 2. Үйл ажиллагааны байдал, судалгаанд хамрагдсан ААН-ийн тоогоор, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Үйл ажиллагааны чиглэл	Нийт ААН-ийн тоо	Хэвийн		Хэвийн бус	
		ААН-ийн тоо	дүнд эзлэх хувь	ААН-ийн тоо	дүнд эзлэх хувь
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	557	350	62.8	207	37.2
Барилга	198	117	59.1	81	40.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	219	103	47.0	116	53.0
Боловсруулах үйлдвэрлэл	218	99	45.4	119	54.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	161	97	60.2	64	39.8
Боловсрол	205	90	43.9	115	56.1
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	115	80	69.6	35	30.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	141	56	39.7	85	60.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	82	49	59.8	33	40.2
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	116	45	38.8	71	61.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	72	35	48.6	37	51.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	77	33	42.9	44	57.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	32	20	62.5	12	37.5
Уул уурхай, олборлолт	31	16	51.6	15	48.4
Мэдээлэл, холбоо	29	16	55.2	13	44.8
Урлаг, үзвэр, тоглоом	39	16	41.0	23	59.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн даатгал	14	11	78.6	3	21.4
Цахилгаан, хий, агааржуулалт	15	10	66.7	5	33.3
Ус хангамж: Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	9	7	77.8	2	22.2
Аялал жуулчлал	72	5	6.9	67	93.1
Нийт	2402	1255	52.2	1147	47.2

Үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа 1255 ААН-ийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар задалж авч үзвэл: 350 (27.9%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар, 117 (9.3%) нь барилгын салбар, 103 (8.2%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, 99 (7.9%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 97 (7.7%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар, 489 (39.0%) нь боловсрол, хүний эрүүл мэнд, нийгмийн халамж зэрэг бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд байна.

Хүснэгт 3. Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа аж ахуйн нэгжийн тоо, 2 судалгааг харьцуулснаар

	Эхний шатны судалгаагаар	2 дахь шатны судалгаагаар
Аж ахуйн нэгжийн тоо	1113	1255

Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа ААН-ийн тоог өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж авч үзвэл, 142 (12.8%) ААН-ээр нэмэгдсэн байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, судалгаанд оролцсон бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг 557 ААН-ийн 37.2 хувийнх нь үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байна гэж хариулжээ.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа 1147 аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл, 207 (18.0%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар, 119 (10.4%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 116 (10.1%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар, 115 (10.0%) нь боловсролын салбар, 85 (7.4%) нь үйлчилгээний бусад салбар, үлдсэн хувь нь барилга, тээвэр, агуулах, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, үл хөдлөх хөрөнгө, мэргэжлийн шинжлэх ухаан болон техник, хүний эрүүл мэнд, нийгмийн халамж, зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд байна.

Хүснэгт 4. Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа аж ахуйн нэгжийн тоо, 2 судалгааг харьцуулснаар

Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа ААН-ийн тоог өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж авч үзвэл, 142 (11%) ААН-ээр буурсан байна.

	Эхний шатны судалгаагаар	2 дахь шатны судалгаагаар
Аж ахуйн нэгжийн тоо	1289	1147

Зураг 1. Үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байгаа аж ахуйн нэгж, салбараар



СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хоёр дахь шатны тандалт судалгаагаар “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вирус (Covid-19)-ээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл”-ийг дараах байдлаар дүгнэж байна. Үүнд:

- Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа ААН-үүдийн 37.2 хувь үйл ажиллагаа нь хэзээ хэвийн болох нь тодорхойгүй гэсэн хариулт өгсөн байна.
- Судалгаанд хамрагдсан ААН-ийн 1251 (52.1%) нь Монгол Улсын Засгийн газраас үе шаттай авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд хамрагдсан байна.
- Зайнаас ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэн ажиллаж байсан ААН-ийн тоо эхний шатны судалгааны үр дүнгээс 300 (29.5%)-гаар буурчээ.
- Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нь ААН-ийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Тухайлбал, хоёр дахь шатны судалгаанд хамрагдсан 1547 (64.4%) ААН-ийн үйл ажиллагаа нь өмнөх улирлаас хүндэрсэн байна.
- Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний нөлөөгөөр орлого нь 50-иас дээш хувиар буурсан ААН-үүдийн хувьд орлого буурсан гэж хариулсан ААН-ийн дүнд эзлэх хувь эхний шатны судалгааны үр дүнгээс даруй 20.5 пунктээр өссөн байна. Энэ нь Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх арга хэмжээний нөлөөгөөр ААН-үүдийн хувьд орлого буурах байдал нь нэмэгдсээр байгааг харуулж байна.

- ААН-үүд тэдний үйл ажиллагааг дэмжих үүднээс Засгийн газраас банкны зээлийн хүүг бууруулах, бага хүүтэй зээл олгохыг арга хэмжээг нэн түрүүнд авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэсэн санал өгсөн байна.

1. Үйл ажиллагаагаа явуулахад учирч буй хүндрэл

Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа 1147 ААН-ийн 502 (43.8%) нь санхүүгийн байдал хүндэрсэн, 427 (37.2%) нь үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан гэж хариулсан нь эхний шатны тандалт судалгааны үр дүнтэй ижил буюу хамгийн их давтагдсан хүндрэл, бэрхшээл болсон байна.

Мөн 416 (36.3%) ААН Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөл хорио тавигдтал үйл ажиллагаагаа түр зогсоосон, 261 (22.8%) нь үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан, 229 (20.0%) нь ажиллагчдынхаа НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон гэсэн бэрхшээлүүдийг дурдсан байна.

Хүснэгт 5. ААН-ийн үйл ажиллагаа явуулахад учирч буй хүндрэл, бэрхшээл, шалтгаанаар

Хүндрэл, бэрхшээлийн төрөл	ААН-ийн тоо	ААН-ийн дүнд эзлэх хувь
Санхүүгийн байдал хүндэрсэн	502	43.8
Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	427	37.2
Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөл хорио тавигдтал үйл ажиллагаагаа түр зогсоосон	416	36.3
Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	261	22.8
Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	229	20.0
Зээл, зээлийн хүү төлөхөд хүндрэлтэй болсон	185	16.1
Бусад	171	14.9
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бусад татвар, хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	160	13.9
Ажиллагчдын тоог бууруулсан	158	13.8
Бусад төлбөр төлөхөд хүндрэлтэй болсон (ус, цахилгаан, дулаан гэх мэт)	140	12.2
Түрээсийн төлбөрөө төлөхөд хүндрэлтэй болсон	115	10.0
Түүхий эд, бараа үйлчилгээний эрэлт эрс буурсан	107	9.3
Төлөвлөсөн хөрөнгө оруулалт хийгдээгүй, хойшлогдсон	102	8.9
Түүхий эд, материал, барааны татан авалт удааширсан	100	8.7
Түүхий эд, материал, барааны нөөц багассан	94	8.2
Түүхий эд, материал, барааны татан авалт зогссон	92	8.0
Түүхий эд, материал, барааны хомсдол үүсэж, дууссан	51	4.4
Түүхий эд, материал, бараа, үйлчилгээг цаг хугацаанд нь хүргэж чадахгүй болсон	47	4.1


Тайлбар: Хариулт нь олон сонголттой бөгөөд олон давтагдсанаар нь эрэмбэлсэн

2. Орлого буурахад үзүүлж буй нөлөө

Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа 1147 ААН-ийн 990 (86.3%) нь Монгол Улсын Засгийн газраас Корона вирусний эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс шалтгаалан орлого буурсан бол 157 (13.7%) нь орлого буурах нөлөө үзүүлээгүй гэсэн хариулт өгчээ.

Орлого буурсан гэж хариулсан 990 аж ахуйн нэгжээс орлогын бууралтыг хувиар тодруулахад, 636 нь орлого нь 50-иас дээш хувь, 129 нь 41-50 хүртэл хувь, 100 нь 31-40 хүртэл хувь, 76 нь 21-30 хүртэл хувь, 37 нь 11-20 хүртэл хувь, 12 нь 10 хүртэл хувиар орлого буурсан гэсэн хариулт өгсөн байна.

Зураг 2. Орлого буурсан ААН, орлогын бүлгээр, дүнд эзлэх хувь



Зураг 3. Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалан орлого буурсан аж ахуйн нэгж, салбараар



Эхний шатны тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад, орлого нь 50-иас дээш хувиар буурсан ААН-үүдийн, орлого буурсан гэж хариулсан ААН-ийн дүнд эзлэх хувь эхний шатны судалгааны үр дүнгээс даруй 20.5 пунктээр өсөж, орлого нь 41-50 хувиар буурсан ААН-ийнх 2.8 пунктээр, 31-40 хувиар буурсан ААН-ийнх 3.5 пунктээр, 21-30 хувь буурсан ААН-ийнх 5.1 пунктээр, 11-20 хувь буурсан ААН-ийнх 4.4 пунктээр, 10 хүртэл хувиар буурсан ААН-ийнх 4.9 пунктээр тус тус буурсан байна.

Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээнээс шалтгаалан орлого нь буурсан гэж хариулсан 990 аж ахуйн нэгжийг эдийн засгийн салбараар харуулбал:

- 172 (17.4%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ
- 106 (10.7%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар
- 106 (10.7%) нь зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 97 (9.8%) нь боловсролын салбар,
- 68 (6.9%) нь тээвэр, агуулахын салбар,
- Үлдсэн хувь нь бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд байна.

Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалан орлого буурсан ААН-үүдийг эхний шатны тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад, бөөний болон жижиглэн

худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-ийн хувьд “Орлого буурсан” гэж хариулсан ААН-ийн дүнд эзлэх хувь 5.9 пунктээр, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ААН-ийнх 1.3 пунктээр, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын ААН-ийнх 1.6 пунктээр, боловсролын салбарын ААН-ийнх 1.5 пунктээр тус тус өссөн байгаа бөгөөд орлого хамгийн ихээр буурсан байдал эдгээр салбаруудад өмнөх судалгааны үр дүнтэй адил хэвээр хадгалагдаж байна.

3. Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээтэй холбоотойгоор ажиллагчдаа даа зайнаас ажиллах боломж олгосон байдал

Судалгаанд хамрагдсан ААН-үүдээс зайнаас ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн эсэхийг тодруулан асуухад 896 (64.1%) нь тийм гэж хариулсан байна. Харин зайнаас ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн 896 ААН-ийн 574 (64.1%) нь энэ арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байна.

Хүснэгт 6. Цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байдал

	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Зайнаас ажиллах нөхцөл, боломж бүрдүүлсэн	896	37.3
Зайнаас ажиллах нөхцөл, боломж бүрдүүлээгүй	1506	62.7
Бүгд	2402	100.0

Хүснэгт 7. Цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөлийг үргэлжлүүлж байгаа байдал

	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Гэрээ ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байгаа	574	64.1
Гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ч үргэлжлүүлэн хэрэгжүүлээгүй	322	35.9
Бүгд	896	100.0

Корона вирусний тархалт эрчимтэй явагдаж, эхний давлагаа хүчтэй өрнөж байх үед судалгаанд хамрагдсан ААНБ-ын 37.3 хувь нь ажиллагчдаа даа цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлж байсан бол одоо 23.9 хувь нь тус арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж, өмнөх судалгаатай харьцуулахад даруй 13.4 хувиар пунктээр буурсан байна.

4. Үйл ажиллагаа хүндэрсэн байдал

Судалгаанд хамрагдсан 2402 ААН-ийн 1547 (64.4%) нь үйл ажиллагаа өмнөх улирлаас илүү хүндэрсэн гэж хариулсан бол 855 (35.6%) нь хүндрээгүй гэж хариулсан байна. Энэ нь Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ нь хугацаа өнгөрөх тусам ААН-ийн үйл ажиллагаанд хүндрэл, бэрхшээл учруулсаар байгааг харуулж байна.

Хүснэгт 8. Үйл ажиллагаа хүндэрсэн байдал

	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Өмнөх улирлаас үйл ажиллагаа хүндэрсэн	1547	64.4
Өмнөх улирлаас үйл ажиллагаа хүндрээгүй	855	35.6
Бүгд	2402	100.0

5. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн шийдвэрт хамрагдсан байдал

Судалгаанд хамрагдсан 2402 ААН-ийн 1251 (52.1%) нь Засгийн газраас авч хэрэгжүүлсэн шийдвэрт хамрагдсан бол 1151 (47.9%) нь уг шийдвэрт хамрагдаагүй байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн шийдвэрт хамрагдсан 1251 ААН-ийг хамрагдсан шийдвэрийн төрлөөр нь авч үзвэл, давхардсан тоогоор,

- НДШ-ийг тэглэх шийдвэрт хамрагдсан – 1089 ААН (45.3%)
- 1.5 тэрбум хүртэлх орлоготой ААНБ-аас орлогын албан татвар авахгүй – 376 (15.7%)
- ААНБ-ын ажилтнуудад сар бүр 200 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэх – 313 (13.0%)

байна.

Хүснэгт 9. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн шийдвэрт хамрагдсан байдал

	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Засгийн газраас авч хэрэгжүүлсэн шийдвэрт хамрагдсан	1251	52.1
Засгийн газраас авч хэрэгжүүлсэн шийдвэрт хамрагдаагүй	1151	47.9
Бүгд	2402	100.0

• Судалгааны үр дүнгээр дээрх 3 арга хэмжээнд зэрэг хамрагдсан 104 ААН байна.

• НДШ-ийг тэглэх, орлогын албан татвар авахгүй байх шийдвэрт зэрэг хамрагдсан 194 ААН,

• НДШ-ийг тэглэх, ААНБ-ын ажилтнуудад сар бүр 200 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэх шийдвэрт зэрэг хамрагдсан 117 ААН байна.

• Харин орлогын албан татвар авахгүй байх болон ААНБ-ын ажилтнуудад сар бүр 200 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэх шийдвэрт хамрагдсан 8 ААН байна.

6. Үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах хугацаа

Судалгаанд хамрагдсан 2402 аж ахуйн нэгжээс Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээ тавигдсанаас хойш үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах хугацааны талаар тодруулсан.

Нийт ААН-ийн 20.9% нь 3 сар хүртэл, 16.7% нь 3-6 сар хүртэл 15.9% нь 6-12 сар хүртэл, 9.3% нь 1 жилээс дээш хугацаа шаардагдана гэж хариулсан байна. Харин 37.2% нь буюу хамгийн их хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж эхлэх хугацаа тодорхойгүй гэсэн хариултыг өгсөн байна.

Хүснэгт 10. Үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах хугацаа, аж ахуйн нэгжийн тоогоор, дүнд эзлэх хувь

Хугацаа	Эхний шатны судалгааны үр дүн	2 дахь шатны судалгааны үр дүн	Өөрчлөлт, пунктээр
3 сар хүртэл	26.3	20.9	-5.3
3-6 сар хүртэл	18.4	16.7	-1.7
6-12 сар хүртэл	14.2	15.9	1.7
1 жилээс дээш	6.3	9.3	3.0
Тодорхойгүй	34.8	37.2	2.4
Бүгд	100.0	100.0	100.0

7. ААН-ээс өгсөн Засгийн газраас цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Судалгаанд хамрагдсан ААН-үүд төр, засгаас дараах төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд:

- Эдийн засгийг богино хугацаанд сэргээх, эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс бодлогын хүүг бууруулах – 1212 ААН
- Зээл авах боломжийг бий болгох бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх – 973 ААН
- Үйл ажиллагааны зардалд тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлэх (цахилгаан, дулаан, ус, түрээсийн зардал гэх мэт) – 921 ААН
- Үйл ажиллагаагаа сэргээхэд гарах асуудлуудыг төрийн бодлогоор шуурхай шийдэхэд дэмжлэг үзүүлэх – 844 ААН
- Эрсдэл, гамшгийн үед ААН-ийн үйл ажиллагаа эдийн засагт учирч болох аюулаас сэргийлэх, даван туулах стратеги, бодлогыг боловсруулах – 762 ААН
- Бусад – 157. Дээр дурдагдснаас бусад төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ААН-ээс өгсөн саналыг олон давтагдсан байдлаар нь эрэмблэн харуулбал,
 - Хил нээх,
 - Хөл хориог цуцлах,
 - Банкны зээлийн хүүг бууруулах, уян хатан системтэй болох,
 - Хувийн хэвшлийн ААН-ийн үйл ажиллагааг дэмжих,
 - НӨАТ-ын хувь хэмжээг бууруулах,
 - Татварыг бууруулах зэрэг саналуудыг өгсөн байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР